



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
E-мэйл: dundgovi@audit.gov.mn

АРДЧИЛСАН НАМЫН ДУНДГОВЬ  
АЙМГИЙН ХУЛД СУМЫН ХОРООНД

2020.07.30 № 137

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Хулд сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Хулд сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050" болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

"Хулд сумын Ардчилсан нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Хулд сумын Ардчилсан нам"-ын мөрийн хөтөлбөр /.../ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хулд сумын сонгуулийн хороонд


Хавсралт .../... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ТӨВСАНАА

0012020447

Хулд сумын Ардчилсан Намын Хорооны  
2020 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн  
3 хурлаар хэлэлцэж батлав.



ХУЛД СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

---

*Handwritten signature*

## **1. ИРГЭД НЬ ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ХУЛДЧУУД**

- 1.1 Эмнэлгийн төсвийг нэмэгдүүлж, эмнэлгийн үйлчилгээг сайжруулахад анхааран ажиллана.
- 1.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах тал дээр анхааран ажиллана
- 1.3 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг бий болгоно.

## **2. ИРГЭД НЬ ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ХУЛДЧУУД**

- 2.1 Багш, удирдах ажилтны мэргэшлийг дээшлүүлж, боловсролын салбарт ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулна. Багшийн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх сургалтуудад багш нарыг тогтмол хамруулна. Багш нарын ажлын цагаа үр дүнтэй өнгөрүүлэх тал дээр анхааран ажиллана.
- 2.2 СӨБ болон ЕБС-ийн багш нарын сургалтын чанарт анхаарч ажиллана.
- 2.3 Сурагчдын сурах хандлага дээр анхаарч, сургалтын чанарыг ахиулан улс аймгийн олимпиадад амжилттай оролцдог болно.

## **3. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД БА СОЁЛ, СПОРТ, НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ**

- 3.1 Соёлын төвийн урд талбайг тохижуулна.
- 3.2 Хуучин соёлын төвийг орон нутгийн музей болгон өөрчилнө.
- 3.3 Хуучин спорт заалаа урлаг заал болгон өөрчилнө.

## **4. ИРГЭД НЬ АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ, АМЬЖИРГААТАЙ ХУЛДЧУУД**

- 4.1 Өрхүүдээр бүл үүсгэн, ажлын байрыг нэмэгдүүлж, өрхийн орлогыг сайжруулна.
- 4.2 “Мэдээлэлжсэн нийгэм”-ийг хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ. Малчдад мэдээллийг түргэн шуурхай хүргэж байна.
- 4.3 Орон нутгийн ахуй үйлчилгээг сайжруулна.
- 4.4 Хүнсний ногоог орон нутагтаа тариалдаг болно.
- 4.5 Зам дагуу байрласан үйлчилгээний газруудаа дэмжиж ажиллана.
- 4.6 Төвдөө цайны газар буудалтай болно.
- 4.7 “Малчид бол жинхэнэ ЖДҮ мөн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. ЖДҮ-ийн зээлийн хүртээмжийг сайжруулна. Малын гаралтай түүхий эдийн жижиг цех байгуулна.
- 4.8 Хороо бууцны гэрчилгээг нэгдсэн байдлаар албажуулна.



*Рамср*

4.9 "Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх зөвлөл байгуулж "Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө" гарган, бэлчээр болон малын эрүүл мэндийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүдтэй холбож, бодлого үйл ажиллагааны хувьд дэмжиж ажиллана.

4.10 Бэлчээрийг усжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. Худаг, усны асуудлыг шийдвэрлэх "

## **5. ИРГЭД НЬ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, ЗАСАГЛАЛ НЬ АРДЧИЛСАН ХУЛДЧУУД**

5.1 Багийн хурлыг тогтмол хийж, мэдээллийг хурдан хүргэж, асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.

5.2 Газар зохион байгуулалтыг хяналтгүй олгодог явдлыг зогсооно. Иргэдэд 0.7 га газрыг олгоно.

5.3 Төрийн албан хаагчийг ажлаас халах, ажлын байрны хөдөлгөөн хийхийг хязгаарлана. Хэт намчирхсан үзлийг байхгүй болгоно.

5.4 Хуулийн тэгш бус үйлчлэлийг зогсооно.

5.5 Хөдөлмөр хамгаалал, нийгмийн хөнгөлөлтүүдийг эздэдээ хүрдэг болгоно.

5.6 Сумаа хөгжүүлэхэд иргэд олон нийтийн санаа бодлыг тусгаж ажиллана.

5.7 Сум хөгжүүлэх сангийн зээлийг зорилтот бүлэгт хүргэх тал дээр анхаарч ажиллана. Зээлийн сонгон шалгаруулалт болон зээл олгох процессыг ил тод нээлттэй болгоно.

## **6. ОРЧИН НЬ АМАР ТАЙВАН АЮУЛГҮЙ СУМ**

6.1 Уул уурхайг орон нутагт үр өгөөжтэй байх тал дээр анхаарч ажиллана.

6.2 Жоншны уурхайг хааж, нөхөн сэргээлт хийх тал дээр анхаарч ажиллана.

6.3 Суманд лиценз маш ихээр нэмэгдэж байгааг багасгах тал дээр анхаарч ажиллана.

## **7. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ӨСӨЛТ ХУЛД НУТАГ**

7.1 Иргэдийн оролцоотой "Шинэ сум" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Сумын төвийг дахин төлөвлөж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн суурин болгон хөгжүүлнэ. Сумын төвийн шинэчлэлийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ. Элсний асуудлыг шийдвэрлэж ногоон байгууламж бий болгоно, сумын гэрэлтүүлэгт анхаарч, засмал зам дагасан эрчим хүч татна.

7.2 Авто замыг сайжруулж, шинэчилнэ. Засмал зам дагуу хогийн сав, боловсон 00 бий болгоно.

7.3 Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийн асуудлыг шийдвэрлэх, жишиг гудамжийг бий болгож, сумын өнгө үзэмжийг сайжруулна. Явган хүний замыг бий болгоно.



*Handwritten signature*

## ХУЛД НУТАГ МИНЬ ҮҮРД МАНДАН БАДРАГ

Мөрийн хөтөлбөр бэлтгэсэн: Дундговь аймгийн Хулд сумын Ардчилсан нам хороо-  
ыг төлөөлж

Нам /эвсэл/-ийн нэр

(тэмдэг)  Дундговь аймгийн Хулд сумын Ардчилсан намын дарга  
-ыг төлөөлж

Овог нэр /Пэрэнлэйн Бямбалхагва/



2020 оны 06 дугаар сарын 22 16:00 цаг



*Рашар*